## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

**САЙНШАНД-БАРУУН-УРТ-ХӨӨТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ БАРИГДСАНААР УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ЖИЛД 55.0 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ТАТВАР ТӨЛБӨР ТӨВЛӨРҮҮЛНЭ.**

**2023-2027**

# 1 САЙНШАНД-БАРУУН-УРТ-ХӨӨТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын **3.2.2.2-**т Сайншанд-Баруун-Урт, **3.2.2.3-**т Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замууд тусгагдсан бөгөөд Засгийн газрын **2012** оны **121** дүгээр тогтоолоор Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон. Засгийн газрын **2022** оны **105** дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтад “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр шууд гэрээ байгуулахаар нэмэлтээр орсон.

Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн **390.5** км урттай төмөр зам ашиглалтад орсноор төмөр замаар жилд **12** сая тн ачаа тээвэрлэнэ.

## ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**2.3 ИХ НАЯД ТӨГРӨГ /урьдчилсан тооцооллоор/**




- ТЭЗҮ ✗
- ЗУРАГ ТӨСӨЛ ✓
- ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ ✗
- БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ ✗
- САНХҮҮЖИЛТ ШИЙДЭГДСЭН ЭСЭХ ✗
- ХОЛБОГДОХ БУСАД ЗӨВШӨӨРӨЛ ✗

## Зам, тээврийн хөгжлийн яам

## 2 УЛААНБААТАР-ХАРХОРИН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ

УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын III үе шатанд, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын II үе шатад хэрэгжүүлэх төсөлд тус тус барихаар тусгагдсан.

УИХ-ын 2023 оны 07 дугаар тогтоолын 2.2-т "Шинэ Хархорум" хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах” гэж тусгасан.

Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүс болохоор төлөвлөгдөж буй “Аэросити” баруун вокзалаас салбарлаж Төв, Архангай аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт шинэ Хархорин суурьшлын бүс хүртэл үргэлжилнэ.

**Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулж, төмөр зам дагуу суурьшлын болон аялал жуулчлалын шинэ томоохон бүс бий болно.
Хархорин хотын бүтээн байгуулалттай холбоотой шаардлагатай барилгын материалын тээвэрлэлтийг гүйцэтгэх боломж бүрдэнэ. Мөн түүнчлэн хоёр хотын хооронд зорчигч тээвэр аялж эхлэх, Хархорин хот өргөжин тэлнэ.**

## ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОЙЛЦООГООР 10.4 ТЭРБУМ АМ/ДОЛЛАР




**2023-2028**

- ТЭЗҮ (+)
- ЗУРАГ ТӨСӨЛ (×)
- ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ (×)
- БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ (×)
- САНХҮҮЖИЛТ ШИЙДЭГДСЭН ЭСЭХ (×)
- ХОЛБОГДОХ БУСАД ЗӨВШӨӨРӨЛ (×)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

## 3 “БОГДХАН” 144.9 КМ ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ

Монгол Улсын Их Хурлын **2020** оны **52** дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-**2050**” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Богдхан төмөр замыг барьж байгуулахаар тусгасан. Энэхүү бүтээн байгуулалт нь төмөр замын дамжин өнгөрөх болон бусад экспорт, импортын ачаа тээврийг Богд уулын урдуур тойруулах, улмаар Улаанбаатар хотын хөдөлгөөний түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх, тээвэр-логистикийн ухаалаг сүлжээг бий болгох зорилготой.

**Улаанбаатар төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

## ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**Ойролцоогоор 792 сая.ам.доллар**





БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

**780**

АЖЛЫН БАЙР

**2024-2025**

| ТЭЗҮ | ЗУРАГ ТӨСӨЛ | ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ | БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ | САНХҮҮЖИЛТ ШИЙДЭГДСЭН ЭСЭХ | ХОЛБОГДОХ БУСАД ЗӨВШӨӨРӨЛ |
|---|---|---|---|---|---|
| ✓ | ✓ | ✓ | ✓ | ✗ | ✓ |

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

ДУНЗЯНЫ ГААЛИЙН БАТАЛГААТ БООМТ" БҮСЭД 50 ЖИЛИЙН ХУГАЦААНД 10 ГА ГАЗРЫГ ХЯТАДЫН ТАЛТАЙ ХАМТАРЧ ЭЗЭМШИН, ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛНЭ.

# 4 МОНГОЛ-ТЯНЬЖИНЫ ДУНЗЯН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ

Монгол Улсын Засгийн газрын **2013** оны **152** дугаар тогтоолоор БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны баталгаат боомтын бүсэд **50** жилийн хугацаатай **10** га газрыг Хятадын талтай хамтран эзэмшиж, ашиглах тухай шийдвэрийг баталсан. Монгол Улсын Засгийн газрын **2019** оны **164** дүгээр тогтоолоор БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсэд Монгол-Хятадын хамтарсан тээвэр логистикийн төв төслийг хэрэгжүүлж, хамтарсан компани байгуулахаар шийдвэрлэсэн.

Монголын талаас төслийн хөрөнгө оруулагчаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны "Өвөр Монголын уурхайн үйлдвэрийн эд хөрөнгийн хамааралтын" ХХК ("ӨМУҮЭХХ" ХХК) шалгарч **2018.12.11**-ний өдөр "Монголын төмөр зам" ТӨХК **51%**, "ӨМУҮЭХХ" ХХК **49%**-ийн хөрөнгө оруулалтай "Монголиан порт групп" ХХК-ийг үүсгэн байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хамтран ажиллах гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, төслийг "Монголын төмөр зам" ТӨХК хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

## ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**34.05 САЯ ДОЛЛАР /урьдчилсан тооцооллоор/**



**ЖИЛИЙН ОРЛОГО**

**$ 5.06 Сая**

**ЖИЛИЙН ЗАРДАЛ**

**$ 3.07 Сая**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НӨХӨХ ХУГАЦАА**

**11.5 жил**

**2024-2025**

ТЭЗҮ | ЗУРАГ ТӨСӨЛ | ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ | БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ | САНХҮҮЖИЛТ | ХОЛБОГДОХ БУСАД ЗӨВШӨӨРӨЛ